

ТҮМЭН ГОЛЫН БҮС НУТГИЙГ НЭЭЛТТЭЙ БҮС БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Д.Баясгалан*

1995 оны 5-р сарын 29-нөөс 6-р сарын 2 хүртэл Бээжинд хуралдсан Түмэн голын нээлттэй бүс нутаг болгон ашиглах хэтөлбөрийг хэрэгжүүлэх хорооны 5-р хурлаас (PMC) ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаа ба Түмэн голын бүс нутгийг нээлттэй бүс болгон хөгжүүлэх асуудал нь нэгэн шинэ үе шатандаа орсныг тэмдэглээд Солонгос, Хятад, Орос гурван улсын төлөөлөгчид "Түмэн голын бүс нутгийг нээлттэй болгох хамтын ажиллагааг зохицуулах зөвлөлийн шийдвэрт гарын үсэг зурсан юм. Мөн Өмнөд Солонгос, Хятад, Орос, Монгол Солонгос зэрэг 5 орны төлөөлөгчид "Түмэн голыг эдийн засгийн нээлттэй бүс нутаг болгон хөгжүүлэх ба Зүүн хойт азийн бүс нутгийн асуудлыг зохицуулах хорооны шийдвэр"-т гарын үсэг зурцгаасан юм. Энэхүү хууль эрхийн хоёр баримт бичиг ба шийдвэр тогтоолын төслүүд нь Түмэн голын бүс нутгийг нээлттэй бүс нутаг болгоход олон улсын хамтын ажиллагааны хууль эрх зүйн анхны үндэс суурь болж өгсөн ба хамтын ажиллагааны улс төрийн ач холбогдлыг өргөж өгсөн юм. 80-аад оны дундаас эрдэмтдийн санаачилгаар анх дэвшигдэн 90-ээд оноос НҮБ-ын дэлхийн бүс нутгуудыг нээлттэй хөгжүүлэх төлөвлөгөө (UNDP) ба олон улсын нийгмийн өөрчлөлтийн үйл явц болон тухайн бүс нутагт хамааралтай олон улсын дэмжлэг, нөлөөгөө ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаа ялангуяа Түмэн голын бүс нутгийг нээлттэй болгох онолын судалгаа төдийгүй практик арга хэмжээ нь хэдийн шинэ үе шатанд гарсан ба олон улсын хамтын ажиллагааг үүнд чиглүүлэх нь энэ зууны нэгэн чухал үйл явдал болж байна. Энэхүү шинэ үе шат нь тохиолдлын чанартай зүйл байгаагүй бөгөөд ЗХА-ийн улс төр, эдийн засгийн хөгжлийн зайлшгүй үр дүн юм. Түмэн голын бүс нутгийг нээлттэй ашиглах олон улсын хамтын ажиллагаанд хэд хэдэн тодорхой нөхцөл үндэс суурь болж өгсөн юм.

1.10 гаруй жил үргэлжилсэн судалгаагаар Хятад, Орос, Солонгос гурван улс Түмэн голын бүс нутгийн байдлыг тодорхой мэдэж ойлгох болсон ба дотоодын эрдэмтэд, улс төрийн зүтгэлтнүүд аж ахуйн ажилтнууд ч өргөн мэдээлэл судалгаатай болсноор Түмэн голын бүс нутгаас гадна ЗХА-ийн бүс нутгийн төв хэсгийг сонирхож эхэлсэн нь эдийн засгийн хамтын ажиллагааны гол цэг болсон юм. Иймээс ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаа болон "Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэх гэсэн хоёр тал нь нарийн холбогдож нөхцөлджээ.

ЗХА-д ийнхүү шинэ "гурвын" холбоо байгуулагдаж Түмэн голын бүс нутагт өдөр ирэх бүр шинэ хүч хуралдаж байгаа нь Түмэн голын бүс нутгийн олон улсын хамтын ажиллагааг нээлттэй болгон хөгжүүлэх үзэл санааны үндэс болж байгаа юм.

2. ЗХА-ийн бүс нутгийн хооронд эдийн засгийн харилцан нөлөөлөл бий болж хөрөнгө оруулалт, техник, тоног төхөөрөмж, ажиллах хүч, аж үйлдвэрийн болон ХАА-н үйлдвэрлэлийн гэх мэт чиглэлээр бүс нутгийн чанартай үйл ажиллагаа өрнөх юм.

3. ЗХА бол улс төрийн бие даасан бүс нутаг төдийгүй эдийн засгийн хамгийн идэвхитэй үйл ажиллагаа явуулагч бүс нутаг юм. Сүүлийн үеийн байдлаас харахад ЗХА бол том гүрнүүдийн өрсөлдөөний

* Д.Баясгалан, ЗХАСТ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд доктор

чухал талбар бөгөөд олон жилийн туршид улс төрийн байдал нөхцөлөөрөө тэргүүлэгч үүрэг гүйцэтгэж байсан юм. Гэвч 80-аад оноос дэлхийн улс төр, эдийн засгийн байдалд гүнзгий өөрчлөлт гарч энх тайван хөгжил дэвшил нь тухайн үеийн гол чиглүүлэгч хүчин болсноор ЗХА-ийн эдийн засгийн роль өдөр ирэх тутам өсөн нэмэгдэж ирсэн байна. Солонгосын хойгийн асуудал, Япон, Оросын хоорондын Курилын арлуудын зэрэг маргаантай асуудлууд энэ бүс нутагт хамрагдаж байсан ч улс төрийн зүтгэлтнүүд болон эрдэмтэд судлаачдын хүчээр их амжилт олж ЗХА-ийн тусгаар бие даасан байдал дор эдийн засгийн олон улсын хамтын ажиллагаа болон бусад харилцааны туслалцаатайгаар дээр дурьдсан улс төрийн асуудлуудыг аажмаар шийдвэрлэж, эдийн засгийг улс төрийн гол нөлөөлөх хүчин болгож чаджээ. Энэ нь ЗХА-ийн болон түмэн голын бүс нутгийн олон улсын хамтын ажиллагааг нээлттэй болгон хөгжүүлэх улс төрийн урьдач үндэс суурь болж өгсөн юм.

4. Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэх нь асар их ахиц дэвшлийг олж байгаагийн дотроос хятадын зүгээс Түмэн голын бүс нутгийг нээлттэй болгон хөгжүүлэх асуудал илзү хурдацтай хөгжиж байна. Солонгосын хойгийг эдийн засаг худалдааны чөлөөт бүс нутаг болгох нээлттэй төлөвлөгөө нь хэдийн хэрэгжиж эхэлсэн төдийгүй Орос улс Түмэн голын хамтын ажиллагаанд оролцох өөрийн онцлог байдлыг харгалзан үзэж нээлттэй байх үндэс сууриа тодорхойлов.

5. Өнөөгөөс эхлэн Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэх бодлого нь олон улсын хамтын ажиллагааг чөлөөтэй нээлттэй болгоход шинэ чухал үе шат болж байна. Энэ үе шатны гол зорилт нь:

а) Олон улсын чөлөөт нээлттэй бүс болгох төлөвлөгөө болон олон улсын хамтын ажиллагааг нээлттэй болгох шаардлагын төлөв нөхцөл дор бие даасан нээлттэй бодлогыг явуулах улмаар үүнийг улам бүр шинжлэх ухааны үндэслэгээтэй болгох

б) Хэтийн төлөвлөгөө ёсоор төмөр зам, авто зам, шуудан холбоо зэрэг дэд бүтцийн барилга байгууламжуудыг барьж байгуулснаар хоёр талын болон олон талын хамтын ажиллагааг нээлттэй хөгжүүлэх

в) Хамтын ажиллагааны нээлттэй байх зарчмыг баримталсанаар улс хоорондын тэгш эрхт харилцааг зөв зохицуулж дээрх зарчмыг улс орон бүрийн эрх ашигт зохицуулж баталгаажуулах юм.

Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэхэд газар зүй, улс төр, эдийн засгийн орчин чухал нөлөөтэй. Энэ хоёр бол хоорондоо салшгүй холбоотой төдийгүй харилцан гүнзгий нөлөөлөлтэй юм. ЗХА-ийн бүс нутгийн улс төрийн байдлыг 80-аад оны сүүлээс авч үзэхэд тухайн бүс нутагт Хятад, Орос, Япон, Америк гэсэн дөрвөн том улс төрийн хүчин эн зэрэгцэн оршиж байсан төдийгүй капиталист социалист хоёр нийгмийн байгуулал болон хөгжингүй болон шинэ тулгар хөгжиж байгаа, хөгжиж буй гэсэн эдийн засгийн гурван байгуулалттай Хятадын зүүн хойт хэсэг, Оросын Алс Дорнод, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Монгол зэрэг зургаан улсын газар нутаг багтаж эдгээр улсууд нь хоорондоо зөрчилдөөнтэй ч зохих хэмжээний харилцаа хамтын ажиллагаатай байв.

ЗХА-ийн бүс нутгийн улс төрийн байдал бусад бүс нутгийн эдийн засгийн үйлдвэрлэлд чухал нөлөөтэй байсан ба байсаар ч байна. Өнөө үеийн олон улсын харилцаанд гарч байгаа их өөрчлөлт хувьсгалын дунд эдийн засгийн хүчин зүйл улам гүнзгийрэн хөгжиж чухал үүрэгтэй болж байгаа билээ. Иймэс ч Түмэн голын бүс нутаг ЗХА-д гол байр суурь эзэлж байгаа нь түүнийг нээлттэй ашиглах гадаад,

дотоод, дундын орчин гэсэн хүчин зүйлүүдээр тодорхойлогдож байгаа юм. Үүнийг доорх байдлаар тайлбарлаж болох юм.



Дотоод орчин гэдэгт Түмэн голд зэргэлдээ оршиж буй Хятад, Орос, Солонгос гэсэн гурван улс багтаж эдгээр нь түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэх эдийн засгийн гол цөм болж байна.

Гадаад орчин нь ЗХА-ийн бүс нутгаас харьцангуй гадна оршиж буй Америк болон бусад бүс нутгийн улсууд орох ба Түмэн голыг хөгжүүлэх хөтөлбөрт гадаад эдийн засгийн хүчин зүйл буюу туслах хүчин нь болж байна.

Дундад орчинд багтаж буй Монгол, Япон, Өмнөд Солонгос улсууд нь Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэхэд шууд буюу дам түлхэц үзүүлэх ач холбогдолтой юм.

Түмэн голтой шууд зэргэлдээ оршин буй Хятад, Орос, Солонгос гурван улс болон гадаад дотоодын хөдөлгөгч хүчин ба НҮБ-ын дэлхийн бүс нутгуудыг нээлттэй хөгжүүлэх бодлого төлөвлөлтийн дор анх Түмэн голын бүс нутгийг нээлттэй ашиглах санал гарч олон улсын эрх зүй хууль ёсны албан баримт бичгүүдээр бүрэн баталгаажсан нь ийнхүү амьдралд нэгэнт хэрэгжиж эхэлжээ.

Хятад улс Түмэн голын бүс нутгийг нээлттэй болгон хөгжүүлснээрээ түүнийг дэлхийн олон улстай харилцан далайн тээврийн гарц болгон ашиглах ба улмаар бусад бүс нутгийн төмөр зам, авто замын сүлжээтэй холбох, далайд гарах гарцаа түрээслүүлэх зэргээр гадаадад нээлттэй байх бодлогоо өргөжүүлснээр өөрийн улсын зүүн хойт бүс нутгийн эдийн засгийн хөгжлөө түргэтгэхийг эрмэлзэж байна.

Хойд Солонгосын хувьд бол 2-3 далайн боомтоо нээлттэй бүс болгосноороо бусад бүс нутгийн олон улстай харилцаа хамтын ажиллагаагаа өргөтгөн хөгжүүлэх сонирхолтой байгаа юм.

Орос улс нь Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлснээр дэлхийн бусад томоохон далайд гарах гарцтай болоход тус дөхөм болно гэж үзэхээс гадна далайн худалдааны нөлөө бүхий боомтуудтай эдийн засаг, худалдааны харилцаагаа өргөжүүлснээр хамтын ажиллагааны нээлттэй бодлогыг өргөн нэвтрүүлж улмаар юуны өмнө Хасаны бүс нутгийн хөгжлийг түргэтгэн хөгжүүлэхэд ашиглах хүсэлтэй байна.

Дээр дурдсан гурван улсын хамтын эрх ашиг болон НҮБ-ын дэлхийн бүс нутгуудыг нээлттэй болгох төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагаас (UNDP) Түмэн голын бүс нутгийг нээлттэй бүс болгох бодлого хоорондоо бүрэн нийцэж байгаа нь Түмэн голтой зэргэлдээ хамгийн ойр оршиж буй Орос, Хятад, Солонгос улсуудын эрх ашиг, туйлын сонирхол ижил байгаа ч эдгээр улс орнуудын хооронд түүх, үндэсний соёл, сэтгэлээний зааг ялгаа байхаас гадна эдийн засгийн эрх ашгийн сонирхол нь ч харилцан адилгүй байна.

Түмэн голыг нээлттэй хөгжүүлэхэд хоёр талын болон олон талын улс төр, эдийн засгийн харилцаа гол үүрэгтэйгээс гадна зохих хэмжээний бэрхшээл эерчил байх нь өргөлзээгүй юм. Хэдий тийм боловч эдгээр асуудлыг олон улсын хамтын ажиллагааны нээлттэй бодлогын хүрэнд бүрэн шийдвэрлэж болно гэж судлаачид үзэж байна. Түмэн голоос дундад орчинд оршдог Монгол, Япон, Өмнөд Солонгос гэсэн гурван улс нь энэ бүс нутгийн эдийн засагт гадаад дотоод чухал нөлөө үзүүлсэн гэж судлаачид үзэж байгаа юм.

Ялангуяа японы далайн боомт хотууд Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэхэд гүнзэг талархалтай байгаагаа илэрхийлцгээж байна. Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэхэд Японы хөрөнгө техник, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн зэрэг хүчин зүйлүүд үйлчилснээр өөрийнх нь зах зээлийн хүрээ тэлж улмаар түүхий эд болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлт нь өссөнөөр эдийн засгийн хөгжлөө улам сайжирна гэж тооцоолж байгаа юм.

Улс төр, эдийн засгийн хүчин зүйлийн байр сууриа илэрхийлж Японы засгийн газраас Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэх улмаар зүүн хойт Азийн бүс нутагт явуулах бодлогоо 1995 оны 2-р сард болсон зүүн хойт Азийн V удаагийн олон улсын хурал дээр тодорхой илэрхийлсэн билээ.

Өмнөд Солонгос улс нь Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэхэд хөрөнгө мөнгөний ихээхэн туслалцаа үзүүлэх гол улс юм. Түүгээр ч барахгүй техник, тэнгэр хөдөө аж ахуйн Зүүн хойт Хятадад болон Орос, Солонгост оруулахад нэн тохиромжтой юм. Мөн Зүүн хойт Азийн хүч тэнцвэргүй байгаа байгалийн баялаг, түүний эд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тэнцвэрийг хангах үндэс суурь болж болох юм гэж үздэг төдийгүй Өмнөд Солонгосын далайн сав газрууд Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэхэд чухал үр нөлөө үзүүлэх юм.

Монгол бол Түмэн голын бүс нутгийг нээлттэй болон хөгжүүлэхэд санал нэгтэй байгаа улс ба Ази, Европыг холбосон зангилааны төв болох юм. Мөн Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлснээр Монгол улс далайд гарах нэгэн гарцтай болж дорнод хэсгийн уул уурхай байгалийн баялагтаа өшиглэн улмаар нээлттэй эдийн засгийн бодлогыг энэ чиглэлд явуулахад тохиромжтой нөхцөл бүрдэж байгаа билээ.

Гадаад орчинд багтаж буй Америк, Канад, Австрали болон баруун европ, умард Европын зэрэг хөгжингүй орнуудын Түмэн голын болон Зүүн хойт Азийн бүс нутгийн хөгжилд нөлөөлөх нөлөө улам бүр их болж байна. Түмэн голын бүс нутаг нь ЗХА-д багтаж байгаа ч дэлхийн эдийн засгийг бүсчилэх явцад гарч байгаа бүс нутгуудын эдийн засаг харилцан нөлөөлөл хамтаралтайг нотлох төдийгүй гадаад эдийн засаг харилцан нөлөөлөл асар их байх юм гэдэг нь тодорхой байгаа юм. Америк улс нь Ази Номхон далайн бүс нутгийн улс төр, эдийн засгийн харилцранд ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа ч зүүн хойт Азийн Япон, Өмнөд Солонгос шиг тухайн бүс нутагтаа ихээхэн хэмжээний цэргийн болон хөрөнгө оруулалт хийгээгүй учраас Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэх хамтын чармайлтанд улс төр эдийн засгийн нөлөө нь бага мэдрэгдэж ажлуу явцтай байгаа билээ.

Умард болон Баруун Европын нэлээд улс орон Түмэн голыг нээлттэй хөгжүүлэх бодлогыг талархан үзэж байгаа бөгөөд эдийн засгийн дэмжлэг үзүүлж улмаар Англи, Франц, Герман, Австрали зэрэг улс орнууд цаашид тухайн бүс нутагт хамтран ажиллахаа илэрхийлж байна.

НҮБ-ын дэлхийн бүс нутгуудыг нээлттэй хөгжүүлэх төлөвлөгөөг

хэрэгжүүлэгч байгууллага (UNDP) болон НҮБ-ын аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагууд (UNDP) Түмэн голын бүс нутгийг хамтын хүчээр нээлттэй бүс нутаг болгон хөгжүүлэх үйл хэрэгт зохион байгуулалтын болон зохицуулалтын олон арга хэмжээг авч байна. НҮБ өдөр тутам өсөн нэмэгдэж буй нийгмийн хөгжлийн чиг хандлага дунд бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг анхааран үэж Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэх нь Ази тивд шийдвэрлэгдэх эн тэргүүний арга хэмжээ гэж үзжээ. 1990-ээд оны турш НҮБ-ын дээрх хоёр байгууллага нь Түмэн голыг нээлттэй бүс нутаг болгон хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн ба цаашид улам их зорилт тавин ажиллаж байгаа юм. Түмэн голыг нээлттэй бүс нутаг болгон хөгжүүлснээр Зүүн хойт Ази, Номхон далайн бүс нутгийг европтой холбогч гүүр нь хойноос өмнийг чиглэсэн Сибирь, Манжуурыг холбосон төмөр зам, Хятадын зүүн хойд хэсэг, Манжуурыг холбосон зам зэрэг гурван хэсэг байх юм гэж өнөө үед судлаачид үзэж байна. Үүнтэй холбогдуулан ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаа болон Түмэн голын бүс нутгийг нээлттэй хөгжүүлэх судалгааг гүнзгийрүүлж Түмэн голын сав газраас эхлэн Зүүн хойт Хятад, Монголын дорнод хэсгийг холбож Ази Европын гүүр болгон өрчлөн байгуулах саналыг тэд мөн дэвшүүлсээр байгаа билээ. Энэ саналыг хэрэгжүүлснээр Монголын эдийн засгийн хөгжил түргэсэх төдийгүй далайд гарах шинэ гарцтай болох юм гэж үзэж байна. Иймээс Ази Европыг холбосон авто болон төмөр зам, шуудан холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх нь чухал гэж тайлбарлаж байгаа билээ.

Дэлхий дахин нийгмийн хөгжлийн өнөөгийн хандлага чиг шугамын дагуу бүс нутагчлах процесс хүчтэй өрнөж буй өнөө үед Зүүн хойт Азийн бүс нутгийг болон Түмэн голын сав газрыг нээлттэй болгон хөгжүүлэх нь нэгэн чухал асуудал болон ийнхүү тавигдаж байна. Энэ асуудал олон орны эрдэмтэд судлаачдын анхаарлыг ихэд татаж тодорхой ажил хэрэг болох бодит алхамдаа хэдийн ороод байгаа билээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Зүүн Хойт Ази судлал, 1996 №4
NORTHEAST ASIA STUDIES. CHINA.
2. Дэлхийн газар зүйн судлал, 1995. №1
WORLD REGIONAL STUDIES
3. Дэлхийн газар зүйн судлал, 1995. №1
4. Зах зээл, 1995 №14
5. XXI зууны Зүүн хойт Ази" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал. 1995 оны 7-р сар. БНХАУ-ын Чаньчүн, Шэньян хот
6. NORT HEAST ASIA ECONOMIC FORUM NEWS LETTER
7. "Ардын эрх", 1997. №4.29.
8. Проблемы Дальнего Востока. 1996. №1 Москва